

“ТҮШИГ-УУЛ” ХК-НИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 4 дүгээр сарын 30-ний 15 цагт Дархан-Уул аймаг Дархан сум 3-р баг өөрийн байранд болов. Тооллогын комисс хувьцаа эзэмшигчдийн ирцийг бүртгэв.
Хурлын ирцийг 15 цагт бүртгэв.

Компанийн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 59,1 хувь буюу 2,568,970 ширхэг хувьцаа эзэмшиж буй 3 хувьцаа эзэмшигч оролцож байгаа тул компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Компанийн тухай хуулийн 69,1 дэх хэсгийг үндэслэн ээлжит хурлыг хүчин төгөлдөр байгааг тооллогын комисс хурлын даргад мэдээлэв. Үүний дараа хурлын дарга Ж.Батсайхан хурлыг нээж дэгийг танилцуулав.

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид:

1. Ж.БАЯРАА /РД 62062018/ 830800 ширхэг хувьцаа эзэмшигч буюу 19,1 %
2. Ж.БАЯНТӨР/РД:ТВ64012611/ 869050 ширхэг хувьцаа эзэмшигч буюу 20,0 %
3. Ж.БАТСАЙХАН/РДТВ71041516/ 869120 ширхэг хувьцаа эзэмшигч буюу 20,0 %

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэв.

Үүнд :

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах
2. Ногдол ашиг хувиарлах тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах
3. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлий дүгнэлтийг хэлэлцэн батлах

Ж.Батсайхан:

Хурлаар хэлэлцэх асуудал бол 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэх батлах мөн цаашдын үйл ажиллагааны талаар хэлэлцэнэ.

2024 оны үйл ажиллагааны тайланг танилцуулав. / тайланг хавсаргав/
Тайлантай холбоотой санал асуулга:

Ж.Баяраа:

2025 онд Хятад улсад үйлдвэрлэсэн насос худалдан авах ажлыг шуурхайлан ажил болгох хэрэгтэй байна. Насос солих засвар үйлчилгээг дагаад бусад сэлбэг материалын зардал гарах нь тодорхой.

Иймд 2024 онд ногдол ашиг хувиарлах эсэх тухайд ногдол ашиг хувиарлахгүй байхаар ТУЗ-ийн шийдвэр гарсан. Үйлдвэрлээд бэлэн бүтээгдэхүүн байхад борлуулах зах зээл ихсэж байна. Иймд чанартай тасралтгүй үйлдвэрлэх ажил маш чухал байна. Цаашид үйлдвэр , машин техникийн засварын материалыг урд хөршөөс захиалах татан авах ажлыг хийх нь чухал байна. Засварын зардал өндөр байна. Тог цахилгаан зардал нилээн нэмэгдлээ. Манай үйлвэрийн засвар үйлчилгээ гар ажиллагаа ихтэй , төмөр замын арчилгаа үйлчилгээ засварын материал үнэ

байнга өсөж байгааг мэдэж байна. Бид боломж бололцоогоороо ажиллаж байгааг ойлгож байгаа. Цаашид ажиллах хүчин нэмэгдүүлэн ажиллах хэрэгтэй.
Ж.Баянтөр:

Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлантай танилцлаа. Барилга их баригдах болжээ. 2025 онд насосоо соливол бүтээгдэхүүний гарц нэмэгдэж засвар багасаж ашигтай ажиллах байх. Хавар талбай дээрээ бүтээгдэхүүн нөөцтэй байвал хавар барилгын ажил эхлэх үед хэрэгтэй байна. Иймээс бүтээгдэхүүн үйлдвэрлэлтэндээ л сайн анхаарч ажиллавал борлохгүй гэх асуудалгүй санагдана.

Ж.Батсайхан: санал асуулгаа үүгээр дуусгаж санал авах хуудсаар саналаа хураая.

Тооллогын комиссын дарга Б.Эрдэнэтуяа:

Хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрсөн санал нь компаний тухай хуулийн 63 дугаар зүйлд заасан хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох хувьд хүрсэн тухай хурлын шийдвэрийг батлах тогтоолын төслийг хувьцаа эзэмшигчдэд танилцуулав. Зөвшөөрсөн 2,568,970 ширхэг хувьцаа буюу 59,1 хувиар батлав.

Ж.Батсайхан тогтоолыг танилцуулав.

1. Тогтоол -1. "Түшиг-Уул" ХК-ны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг баталсугай.
Хэлэлцэх асуудал дууссан тул хурлыг дуусгав.



ХУРЛЫН ДАРГА

Ж.БАТСАЙХАН/